

**СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН
СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ
ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ
ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 03 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан зорилтыг хангах, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс бий болсон үр дагаврыг арилгах, согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахаас үүдэлтэй эрсдлийг бууруулах ажлыг үр дүнтэй, оновчтой зохион байгуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зэрэг зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 35 хувиас дээш хатуулагтай этилийн спирт агуулсан согтууруулах ундааг лонх, савлагаатай нь худалдаж үйлчлэхийг хориглох нь оновчтой эсэх талаар, түүнчлэн согтууруулах ундааны нэр, лого, барааны тэмдэгт түүхэн хүний нэр, зургийг ашиглахыг хориглохоор төсөлд тусгасан бөгөөд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар түүхэн хүний нэр, зургийг ашиглаж байгаа согтууруулах ундаа үйлдвэрлэгчдийг хэрхэн зохицуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох өдрийг хуульчлах шаардлагатай эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа согтууруулах ундааг татваргүй барааны дэлгүүрээр дамжуулж худалдаалахтай холбогдуулан олон сөрөг үр дагавар үүсч байгаа тул үүнтэй тэмцэх бодлогын талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр архидан согтуурахтай тэмцэх санд төвлөрөх хөрөнгө, түүний зарцуулалтын талаар болон хэрэглэгч согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэснээс үүссэн гэм хорын асуудлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцах зохицуулалтыг төсөлд тусгасан нь зөв эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт согтууруулах ундаагаар үйлчлэх хугацааг хуульчлах нь зохистой эсэх, түүнчлэн жирэмсэн хүн согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон нь оновчтой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг архидан согтуурахтай тэмцэх төрийн бодлогыг өөрчлөх, захиргааны шинжтэй хориглох арга хэмжээ нь согтууруулах ундааны үйлдвэрлэгчдэд бус хэрэглэгчдэд чиглэсэн байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн чөлөөт бүсэд сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг чөлөөт бүсийн захирагч олгох асуудлыг тус хуулиар бус Чөлөөт бүсийн тухай хуулиар зохицуулах, согтууруулах ундаа үйлдвэрлэх хатуулгийн дээд хэмжээг тогтоон хуульчлах, түүнчлэн төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлж, ажлын байран дээр согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдолд ажлаас халах зохицуулалтыг тусгах талаар, Улсын Их Хурлын гишүүн

Д.Ганбат согтууруулах ундаанаас хамааралтай байх, архинд донтох явдал нь өвчин тул архидан согтуурахтай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг согтууруулах ундааны зохистой хэрэглээг бий болгох, олон улсын чиг хандлагад нийцсэн зохицуулалтыг төсөлд тусгах шаардлагатай талаар санал хэлсэн болно.


Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 89.9 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



С.БЯМБАЦОГТ